

МОНГОЛ УЛСЫГ ХӨГЖҮҮЛЭХ ТАВАН ЖИЛИЙН
ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН 2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ХЭРЭГЖИЛТЭД
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН ТАЙЛАН

2024.12.05

Улаанбаатар хот

Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 23 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”, “Монгол Улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр”-ийн хэрэгжилтэд Биеийн тамир, спортын улсын хороо хэрэгжүүлэхээр тусгагдсан арга хэмжээний 2024 оны жилийн эцсийн хэрэгжилтийг төлөвлөсөн зорилт, арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшний хэрэгжилт харьцуулан тооцож, үр дүнг үнэлэн, дүгнэлт өгч, зөвлөмж боловсруулан, удирдлагыг үнэн бодит мэдээллээр хангах, төлөвлөсөн зорилтыг бүрэн биелүүлэхэд дэмжлэг үзүүлэх, үйл ажиллагааны гүйцэтгэл, үр дүн, үр нөлөөг нэмэгдүүлэх, хэрэгжилт, хариуцлагыг сайжруулахад хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго оршино.

Хоёр. Хяналт-шинжилгээ, үндэслэл, үнэлгээний арга зүй

Засгийн газрын 2020 оны “Журам шинэчлэн батлах тухай” 206 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 6.2.1, 6.2.2-т заасан аргачлалыг удирдлага болгов.

Монгол Улсын 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, “Монгол Улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр” -ийн хэрэгжилтийг салбарын зорилт, арга хэмжээний 2024 оны жилийн эцсийн тайлан ажлын бодит үр дүнг, хүрэх түвшинтэй харьцуулан биелэлтийг хувиар тодорхойлж, зорилтын хэрэгжилтийг дараах ангилалд шилжүүлэн тооцлоо. Үүнд:

- “үр дүнтэй” 100 хувь;
- “тодорхой үр дүнд хүрсэн” 70 – 100 хүртэл хувь;
- “эрчимжүүлэх шаардлагатай” 30 – 70 хүртэл хувь;
- “үр дүнгүй” 0- 30% үнэлгээг гаргалаа.

Гурав. Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүн

Биеийн тамир, спортын салбарын хүрээнд 1 зорилт 4 арга хэмжээний хэрэгжилтийн 2023 оны тайланд хяналт-шинжилгээ, үнэлгээг гүйцэтгэлээ.

Монгол Улсын 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, “Монгол Улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр” -ийн 2024 оны жилийн эцэст зорилтын дундаж 97 хувьтай, буюу “Тодорхой үр дүнд хүрсэн” байна.

№	Дэс дугаар	Зорилт, арга хэмжээ	Гүйцэтгэл хувь
3. ГУРАВ. АМЬДРАЛЫН ЧАНАР БА ДУНДАЖ ДАВХАРГА			
3.5. Биеийн тамир, спортын чанар, хүртээмжтэй, үр дүнтэй тогтолцоог бүрдүүлнэ.			
1.	3.5.1	Хүн амд биеийн тамир, спортын үйлчилгээ үзүүлэх төр, хувийн хэвшлийн түншлэлд суурилсан нээлттэй, уян хатан тогтолцоог бүрдүүлнэ.	100%
	3.5.2	Иргэдэд үйлчлэх спортын зориулалтын стандарт талбайн хүртээмж нэмэгдэнэ.	90%
	3.5.3.	Нийтийн биеийн тамирыг эрүүл, идэвхтэй амьдралын хэв маяг, аж төрөх ёсны салшгүй хэсэг болгон хөгжүүлнэ.	100%
	3.5.4.	Мэргэжлийн спортыг дэмжиж, тамирчдын чадвар, амжилт дээшилсэн байна	100%
Зорилтын дундаж үнэлгээ			97%

Дөрөв. Дүгнэлт.

Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн биеийн тамир, спортын салбарын 2024 оны жилийн эцсийн тайлан “Тодорхой үр дүнд хүрсэн” байна гэж дүгнэлээ. 2023 оны жилийн эцэст хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээнд тусгасан дүгнэлт, зөвлөмжийг хэрэгжүүлж зорилтын хувийг 5%-р нэмэгдүүлсэн нь удирдлага зохион байгуулалт сайтай, үр дүнтэй ажилласан байна гэж үзэж байна. Цаашид Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн зорилтын хэрэгжилтийг “үр дүнтэй” буюу 100 хувьд хүргэн ажиллах шаардлагатай байна.

Тав. Зөвлөмж

1. Монгол Улсад ашиглагдаж байгаа спортын заалны мэдээллийг статистикийн тоон мэдээлэлтэй тайлагнаж байхыг Бодлого, төлөвлөлтийн газарт,

2. Монгол Улсын Их Хурлын 2020 оны 23 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 2025 оны төлөвлөгөөний хэрэгжилтэд анхаарч зорилтын хувийг бууруулахгүй хадгалж “үр дүнд” хүргэн ажиллахыг бүх хэлтэс газарт тус тус зөвлөмжилж байна.

ХЯНАЖ БАТАЛГААЖУУЛСАН:
ХШУДАХ-ИЙН ДАРГА

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ ХИЙСЭН:
ХШУДАХ-ИЙН МЭРГЭЖИЛТЭН



Н.БАТСҮХ

Д.УРАНБИЛИГ